

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2020-12-15/**

Ажлын хэсгийн 52 дугаар хуралдаан 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 10.30 цагт цахим хэлбэрээр зохион байгуулагдав.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалыг орлож Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, шинжээч Г.Мишээлт, Авилгатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга С.Дуламсүрэн, Эрдэнэс монгол ХХК-ийн хяналт, мониторингийн албаны дарга Д.Баттулга, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Оюутолгой ХХК-ийн менежер Б.Ренчинпагма, ахлах менежер Т.Мөнхбат, Рио Тинто Монгол ХХК-ын менежер н.Даваасүрэн, Петроматад ХХК-ийн ерөнхий нябо Отгонбаяр, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнпүрэв, Транспаренси Интернейшнл Монгол байгууллагын ерөнхийлөгч Л.Төр-Од, Их баяншарга ТББ-ын тэргүүн Л.Бор, МБОИЗ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, МБОИЗ-ын гишүүн Н.Эрдэнэсайхан болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 18 гишүүн оролцож, ирц 54 хувьтай байв.

Мөн хуралдаанд Грант Торnton аудит ХХК-ны партнер Н.Эрдэнэцог, Б.Дэлгэрмаа, О.Идшинринжин, АХБ-ны ОҮЗСТөслийн зохицуулагч З.Баярхүү, Мэдээлэл технологийн зөвлөх В.Нармандах, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны газрын дарга Э.Батболд нээж үг хэлэв.

Э.Батболд: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Цар тахлын улмаас бид Ажлын хэсгийн 52 дугаар хуралдааныг цахимаар хийж байна. Цаг үеийн нөхцөл байдал биднийг цахимаар ажиллаж, сурахыг шаардаж байна. Иймд бид халдварт хамгаалалтын дэглэмээ сахиж ажиллах тъо оорийгоо болоод бусдыг халдвараас сэргийлэх учиртай билээ. Хурлын хөтөлбөр бусад материалуудыг цахимаар та бүхэнд хүргүүлсэн бөгөөд танилцаж амжсан гэдэгт итгэлтэй байна. Хуралдаан маань ажил хэрэгч, бүтээлч уур амьсгалд болно гэдэгт итгэж байна. 2020 онд олон томоохон үйл явдал болсон бөгөөд үүний нэг нь Улсын их хурлын сонгууль байлаа. Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан шинэ Засгийн газар 2021-2024 оны Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.2-т “Ил тод хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялагийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгаа шударга хуваарилах зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс хий, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг бүтээн байгуулалтыг эхлүүлж, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Мөн 3.2.6-д “хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно” гэсэн зорилтуудыг тавьсан байдаг. ОҮИТБС-ын оролцогч талууд маань эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахыгuriалж байна. Нөгөө талаас санаачилгын олон улсын стандартыг хэрэгжүүлэх нь бидний үйл ажиллагааны бас нэг чиглэл байх болно. 2021 онд Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль, Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу хэд хэдэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулахаар төлөвлөөд байна. Иймээс хуулийн төслүүдийг чанартай бэлтгэх, холбогдох хэлэлцүүлгүүдийг заасан хугацаандаа зохион байгуулах болно. Түүнчлэн ил тод байдлын санаачилга болон олборлох үйлдвэрлэлийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, тайлан мэдээг ойлгомжтой байдлаар боловсруулж түгээх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, дэд зөвлөлүүдийг чадавхжуулахад бид бүхэн анхаарч ажиллах болно. Ингээд хуралдаанд амжилт хүсье, баярлалаа. Хурлаа Цолмон гуай удирдаад явна уу.

Техникийн саатал гарснаас шалтгаалаан эхлээд 2 дугаар асуудлаа, дараа нь 1-р асуудлаа хэлэлцсэн болно.

Танилцуулга хоёр: Монголын ОҮИТБС-ын 2020 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2021 оны төлөвлөгөөний төслийн танилцуулга

Ш.Цолмон: Сайн байцгаана уу, Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Азийн Хөгжлийн банкны техник туслалцааны төсөл болон 2020 оны ОҮИТБС-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байгаа ажлын тоймыг танилцуулж байна. ОҮИТБС-ын 2020 оны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэлхий даяар тархаад байгаа Covid-19 вирусын улмаас үүссэн олон нийтийн хөл хорио болон УИХ, орон нутгийн сонгууль давхацсан нь тус төлөвлөгөөний зарим ажлууд хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгосон. Гэвч компани, аж ахуйн нэгжүүд, төрийн байгууллагуудтай цахим болон зайнлас харилцаж үндсэн гол ажлуудаа хэрэгжүүлж чадсан болно. Тухайлбал, ОҮИТБС-ын 2019 оны шинэ стандартын маягуудыг батлуулж, мөрдүүлэн, цахим тайланг цаг хугацаанд нь гаргасан. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулсан. ОҮИТБС-ын 2019 оны нэгтгэл тайлан боловсруулах ажлыг зохион байгуулав. Covid-19 цар тахалтай холбогдуулан цахим хурал, семинаруудыг хийх замаар бусад ажлуудыг зохион байгуулсан.

Дэлхийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд хийгдэх ёстой байсан олон үйл ажиллагааг хойшлуулан, 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэснийг танилцуулья.

2021 онд 18 зорилт, 64 үйл ажиллагаа бүхий Монголын ОҮИТБС-ын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, төслийг танилцуулж байна. Уг төлөвлөгөөг боловсруулахдаа 2020 оны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл, Олон улсын ОҮИТБС-ын Удирдах хорооноос гаргасан санал, зөвлөмж; ОҮИТБС-ын Ажлын хэсгийн 51 дүгээр хурлаас гарсан санал, зөвлөмж, 2019 оны нэгтгэл тайлангийн эхлэлийн семинар дээр Ажлын хэсгийн гишүүдээс гарсан санал, зөвлөмж, ОҮИТБС-ын тайлан, мэдээг ашиглагч байгууллагын төлөөлөл /ОУСК/-ийн санал, зөвлөмж, Covid-19 цар тахлын эрсдэл зэргийг харгалзан боловсруулсан. Ажлын төлөвлөгөөг 1)Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, эцэслэх 2)ОҮИТБС-ын шинэ стандартын шаардлагуудыг хангах, тайлангийн системийг шинэчлэх, төр байгууллага, эрдэс баялгийн салбарт төсөл хэрэгжүүлж буй компаниуд 100 хувь тайлангаа гаргах 3)Гэрээний ил тод байдлыг 2021 оны 1 дүгээр сарын 1-нээр хангах 4) Уян хатан нэгтгэл тайланг боловсруулж батлах 5) ОҮИТБС-ын тайлан, мэдээллийг иргэд олон нийтэд зориулан ойлгомжтой байдлаар боловсруулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх 6) Үндэсний түвшний мэдээлэл харилцааг идэвхжүүлэх 7)Орон нутгийн түвшинд иргэдэд мэдлэг ойлголт өгөх, үйл ажиллагааг сурталчилан таниулах, оролцоог хөхүүлэн дэмжих, хамтын ажиллагаа түншлэлийн хэлбэрүүд бий болгох 8)ОҮИТБС-ын мэдээлэл, харилцаа, сурталчилгааны ажил, хэвлэн нийтлэх материал боловсруулах, хэвлэх түгээх 9)Дэд зөвлөлүүдийг чадавхжуулах хэрэгцээний суурь судалгаа, стратеги боловсруулах 10)Дэд зөвлөлүүдийг чадавхжуулах сургалт, семинарын үйл ажиллагааг чанаржуулах 11) Бус нуттуудад чуулган семинарууд зохион байгуулж, дэд зөвлөлүүдийн чадавхийг бэхжүүлэх 12) 2018, 2019 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зэрэг нийт 18 зорилтуудыг хүрээнд 64 үйл ажиллагааг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Монголын ОҮИТБС-ын 2020 оны уян хатан нэгтгэл тайланг хугацаанд нь чанартай гаргахад бүх талууд сайтар анхаарч, тайлангаа хугацаанд чанартай гаргахад хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна. Санхүүжилтийг АХБ 110 сая, Улсын төсөв 162 сая төгрөгийг хариуцна гэж тооцож харин 102 сая төгрөгийн ажлыг бусад эх үүсвэрээс олно гэж тооцоолсон. Оролцогч талуудаас ирэх онд өөрийн зүгээс оруулах ажлыг 2021 оны үйл ажиллагааны төлөвлөөнд оруулах талаар санал, санхүүжилтийн санал байвал оруулах бүрэн бололцоотой гэж үзэж байна. Мөн эдгээр санал болгосон үйл ажиллагаануудын талаар зөвлөмж, чиглэл өгөх нь зүйтэй. Анхаарал тавьсанд баярлалаа. (Танилцуултыг хавсаргав)

3.Баярхүү: Бид өмнө 2020 оны төлөвлөгөөг Дэд зөвлөлийг чадавхжуулах гэсэн уриан дор боловсруулж байсан. Гэвч энэ үйл ажиллагаа нь Ковидтой холбоотой, Улсын их хурлын болон Орон нутгийн сонгуультай холбоотойгоор хойшилсон, үргэлжлээд хөл хорио залгасан

байна. 2021 оны ажлын төлөвлөгөөг ОҮИТБС-ын хууль эрхзүйн орчноо сайжруулах, хуулиа баттуулъя гэсэн уриатай мөн олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулсан. 2020 онд дэд зөвлөлийг чадавхжуулах ажлыг хийж чадаагүй учраас дараа оны төлөвлөгөөнд тусгай нэг бүлэг болгон оруулсан. Өмнө жилүүдийн ажлын төлөвлөгөөнд ОҮИТБС-ын суурь ажлуудыг хийхэд чиглэж байсан тухайлбал, тайлан авах, мэдээ тайланг гаргуулах, нэгтгэл тайлан гаргах гэх мэт. Бид 2021 онд ил тод болгож байгаа мэдээллээ яаж олон нийтэд хүргэх вэ гэдэг дээр төвлөрч ажиллана. Мэдээж хэрэг өмнөх хийж байсан суурь ажлуудаа сайжруулах шаардлага байгаа. Мэдээллийг олон нийтэд хүргэхийн тулд нилээд олон үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн. Мэдээллийг ямар хэлбэрээр, ойлгомжтой олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар гаргах вэ, гаргасан мэдээллийг ямар хүмүүс хэрхэн ашиглаж байна, төрийн байгууллагууд хэр ашиглаж байна вэ зэргийг судалж цаашдаа мэдээллийг олон нийтэд хүргэх, шаардлагыг нь хангах тал дээр фокуслаж ажиллаж гэж төлөвлөсөн. Зөвхөн 2021 он ч гэлтгүй цаашдаа ил тод болгосон мэдээллээ хэрхэн олон нийтэд хүргэх талаар анхаарч ажиллана. Олон улсын ОҮИТБС-ын Удирдах зөвлөлөөс мөн мэдээллийг олон нийтэд хүргэх зорилтыг тавьсан байна. Иймээс гишүүн орнууд хүртэл энэ зорилтоор ажиллах ёстой гэж бодож байна. 2021 оны төлөвлөгөө ч энэ чиглэл рүү түлхүү анхаарч, хийж эхлэхээр төлөвлөсөн байна.

Н.Дорждарь: Манай байгууллагын зүгээс ОҮИТБС-ын ажлын албанд нэгэн саналыг хүргүүлсэн. Энэ нь ажлын төлөвлөгөөтэй холбоотой учраас одоо танилцуулчихъя. Манай байгууллага Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)- тэй хамтран ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч гишүүн орнуудын нэгтгэл тайланг авилгын эрсдэлтэй уялдуулан судлах судалгааг хийж байгаа. Энэ жил Эрдэс баялгийн салбар дахь авилгын эрсдэлийг тодорхойлох судалгааг манай байгууллага гаргасан. ОҮИТБС-ын олон улсын ажлын албанаас дараа жилээс гишүүн орнуудад дээрх судалгааг хийх, судалгаатай уялдуулан нэгтгэл тайланг бэлтгэх ажлыг хийх саналтай байгаа. Үүнээс өмнө нэг орныг туршилтын журмаар энэ судалгаанд хамруулах бөгөөд үүнд Монгол улсыг оруулах санал бидэнд байгаа юм. Монголын ОҮИТБС нь хэрэгжүүлэгч орнуудын дунд нилээд сайн ажиллагаатай, шинийг санаачлагч улс орны тоонд ордог. Ингээд хэрвээ ОҮИТБС-ын Ажлын хэсэг зөвшөөрвөл 2021 онд манай байгууллагын боловсруулсан судалгааны аргачлалыг ашиглан энэ судалгаанд хамтран ажиллах саналыг тавьж байна. Энэ ажлын судлаачдын зардлыг манай байгууллагаас гаргахаар байгаа. Авилгыг оношлох хэрэгсэл нь эрдэс баялагийн салбарын бүхий л шат дамжлагыг хамрах юм. Монгол улсын хувьд бүхий л арга хэрэгслийг ашиглаж судалгааг хийх эсвэл тодорхой хэсгүүдийг ашиглаж хийх үү гэдэг нь ажлын хэсгийн хувьд сонголт нь нээлттэй байгаа. Бид энэ асуудлаар захидал хүргүүлсэн байгаа, албан ёсоор хариу өгөөд зөвшөөрвөл 2021 оны ажлын төлөвлөгөөнд оруулж ажиллах боломжтой байгаа. Нэмэлт асуулт, тодруулга байвал холбогдоход бэлэн байна, баярлалаа.

Д.Эрдэнэчимэг: Дорждарийн танилцуулсан асуудлыг одоо хэлэлцээд явах уу, тэр цаг дээр нь ярих юм уу? Одоо шийдэхээр бол ажлын хэсгийг гишүүдээс санал аваад оруулах санал байна. 2020 оны тайлан нь зөвхөн ажлын албаны хийсэн ажил биш Ажлын хэсгийн гишүүн байгууллагуудын хийсэн ажлууд нэгдэж орох байх. Ил тод болсон мэдээллийг олон нийтэд хүргэх үүднээс манай байгууллага Олон улсын санхүүгийн корпорацитай хамтраад, УҮХҮЯ-ны дэмжлэгтэйгээр “Уул уурхайг өгөгдлөөр урлахуй” гэсэн дата хакатоныг зохион байгуулж байгаа. Энэ нь олборлох салбаруудыг тойрсон дата өгөгдлийн сангуудын ашиглалтыг нэмэгдүүлэх, мэдээллийг санг боловсруулах цаашлаад олон нийтэд хүргэхэд мэргэжилтэй залуучуудын оролцоог хангах зорилготой. Одоогоор эцсийн дун нь гараагүй байгаа, энэ долоо хоногт буюу 18-ны 18 цагаас шалгарсан 8 бүтээлийг шууд дамжуулах юм. Ажлын хэсгийн гишүүд маань үүнийг заавал үзээрэй, энэ тэмцээний хамгийн том бааз суурь ОҮИТБС-ын тайлангуудын мэдээлэл байгаа, урилга линкийг тухайн үед нь хүргүүлнэ. Үүний нэг онцлог нь тайлангийн мэдээллүүдийг төрийн мэдээллийн нэгдсэн санд нэгтгэн байршуулсан. Цаашдаа мэдээлэлтэй ажиллах хүмүүс энэ эх үүсвэрээс ОҮИТБС-ын тайлангийн шаардлага хангасан мэдээллийг авч ашиглах боломжтой болж байгаа. Мөн цаашдаа шинээр гарч байгаа мэдээллээ энд байршуулаад байвал хүнд хэрэгтэй, хүртээмжтэй эх сурвалж болно гэж бодож байгаа.

Ажлын төлөвлөгөөтэй холбоотой “эцсийн өмчлөгчийг ил тод болгох” олон улсын өмнө хүлээсэн үүрэг маань 2020 оны 12 сард дуусч байгаа. Иймд энэ үүргийн хэрэгжилтийг хэрхэн хангасан бэ гэдгийг дүгнэж үзмээр байна. Одоо улсын бүртгэл, татварын байгууллага дээр эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэж байгаа. Авилгатай тэмцэх газартай хамтраад судалгаа хийж байсан үүнд эцсийн өмчлөгчийн дөнгөж 30 хувь нь бүртгүүлсэн гэсэн мэдээлэл гарсан. Энэ жил хэдий хэмжээний өмчлөгч нэмэгдсэн бол энэ талаар судалж үзмээр байна. Мөн Улсын бүртгэлийн газарт мэдээлэгдэж байгаа мэдээллийг ил тод болгох асуудлаар ажлын хэсгийн зүгээс санаачлагатай ажилламаар байна. Бид ОУИТБС-ын тайлангаараа ил тод болгож байгаа гэж үзэж байгаа гэвч хангальтай биш байна. ОУИТБС-ын шаардлагад эцсийн өмчлөгчийг ил тод болгохоор заасан байдаг. Ил тод байдлын хуулийн төслийн ажил явагдаж байгаа, хууль батлагдахаас өмнө ямар ажил хийх вэ гэдгээ ярьмаар байна, баярлалаа.

Н.Баярсайхан: Ажлын төлөвлөгөөний биелэлт, 2021 оны төслийг урьдчилан хүлээн авч, саналаа хүргүүлсэн, саналыг тусгасанд баярлалаа. Манай Хил хязгааргүй алхам байгууллага ажлын албатай хамтран “гэрээг хэрхэн байгуулах вэ” гэсэн гарын авлагыг боловсруулж, хэвлэж гаргасан. Мөн Нээлттэй нийгэм форум, Байгалийн баялагийн засаглалыг хүрээлэн хамтран цахим гарын авлагыг бэлтгэсэн энэ хоёрыг тайландаа дурдаж оруулах саналтай байна. Ажлын алба маань ажлынхаа арга барилыг өөрчлөх талаар ирэх ондоо бодмоор байна. Бүх ажлыг ажлын алба гээд орхидог, ажлын алба хүний нөөц багатай байгаа иймд талуудыг оролцоог нэмэгдүүлж, ажлын төлөвлөгөөг биелүүлэхэд татан оролцуулж чиглүүлэгчээр ажилламаар байна. Ажлын дэд хэсгүүдийг байгуулах, санаачилга гаргасан идэвхтэй ажиллаж байгаа гишүүдийг хөхүүлэн дэмждэг өөр арга барил руу шилжиж 2021 онд өөр түвшинд ажиллаасай гэж бодож байна. Үүнийг хурлын тэмдэглэлд тэмдэглүүлэхийг хүсэж байна. Хүний нөөц маш бага байна, боловсон хүчин орж ирэхгүй байхад ажлын алба бүх ажлыг өөр дээрээ авахаар ажлын чанарт нөлөөлж байгаа учраас энэ асуудал дээр анхаарах саналтай байна.

Ш.Цолмон: За баярлалаа, саналуудыг хүлээн авч, оруулья. Мэдээллийн зөвлөх Мөнхбат маань албан ёсоор ажлаа өгсөн, оронд нь Нармандах гэж залуу ажиллаж байгаа, өнөөдрийн цахим хурлын хостинг хийж байгаа.

Б.Батболд: 2021 оны төлөвлөгөөнд мэдээллийг олон нийтэд ил тод болгох зорилтыг тавьж байгаа юм байна. Энэ талаар санхүүгийн зардлыг хаана яаж тусгаж оруулсан бэ? Өөрөөр хэлбэл мэдээллийг жирийн иргэдэд хүргэхэд ямар ажлыг зохион байгуулах, түүнийг ямар хөрөнгө мөнгөөр хийх вэ энэ талаар тодруулна уу.

3.Баярхүү: Ажлын төлөвлөгөөний зорилтын 8-д ОУИТБС-ын тайлан, мэдээллийг иргэд олон нийтэд зориулан ойлгомжтой байдлаар боловсруулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлуудыг тус бүрээр нь оруулсан байгаа. Тухайлбал, төлөвлөгөөний 8.1-д ОУИТБС-аас гаргаж буй мэдээлэл, тайлангийн хэрэгцээ шаардлагыг хэрэглэгчийн бүрэг тус бүрээр тодорхойлж гаргах судалгаа хийх ажлыг хамгийн эхэнд тавьсан байгаа, үүнд санхүүгийн эх үүсвэрт 25 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгасан. Түүнчлэн 8.2 дугаар ажлыг хийхэд ОУСК-тай хамтран ажиллана, 8.3 болон 8.4 дүгээр ажлуудыг зохион байгуулахад улсын төсвийн санхүүжилтээр хийхээр тусгасан байна. ОУИТБС-тай холбоотой тайлан мэдээллийн цахим сайт, сувгуудыг нэгтгэж, мэдээллийн нэгдсэн бааз бий болгосноор мэдээллийг нэг эх сурвалжаар авахад хялбар болох юм. Энэ зорилт дээр та бүхэн саналаа өгөөрэй. Мөн олон нийтийн мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд үндэсний түвшний мэдээлэл харилцааг идэвхжүүлэх ажлуудыг хийхээр 9.1-9.4т тусгасан байна.Үүнд: мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлэх, ТББ, бодлогын хүрээлэн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд Монгол дахь ОУИТБС-ын хэрэгжилтийн үр нөлөө, ач холбогдол, цаашдын зорилтыг танилцуулах, орон нутгийн төр захиргааны байгууллагууд, тэдгээрийн удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдийн тогтмол мэдээллээр хангах, харилцан мэдээлэл солилцох цахим сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Түүнчлэн зорилт 10-т Орон нутгийн түвшинд иргэдэд мэдлэг ойлголт

өгөх, үйл ажиллагааг сурталчилан таниулах, оролцогг хөхүүлэн дэмжих, түншлэлийн хэлбэрүүд бий болгох, зорилт 11-д ОҮ-ийн мэдээлэл, харилцаа сурчилгааны ажил, хэвлэн нийтлэх материал боловсруулах, хэвлэн түгээх ажлын хүрээнд ОҮ-ийн мэдээлэл харилцаа, сурчилгааны стратегийн дагуу ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах, харилцаа мэдээллийн ажлыг гүйцэтгэх PR ын зөвлөх үйлчилгээ авах зэрэг ажлуудыг зохион байгуулахаар тусгасан байна.

Ш.Цолмон: За баярлалаа, дэлгэрэнгүй мэдээллийг хүргэлээ.

Н.Баярсайхан: ББЗХ-ээс гаргасан санал нь 2021 оны ажлын төлөвлөгөөний 1 болон 6 дугаар зорилтуудтай шууд холбоотой учраас одоо хэлэлцээд, төлөвлөгөөндөө тусгах саналтай байна.

Ш.Цолмон: За баярлалаа, 2 дугаар асуудалтай холбоотой шийдвэрийн төслийг гишүүдэд тараасан байгаа. Өөр гишүүдээс санал байхгүй бол Баярсайханы гаргасан саналыг хөлбогдох зорилтод нэмж тусгаад Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж батлуулахаар бэлтгэе. Өөр саналтай хүн байна уу?

Д.Цэрэнжав: Нөхцөл байдалтай холбогдуулаад 2020 оны төлөвлөгөөний биелэлтэд хэлэх юм алга. Харин 2021 онд хийхээр төлөвлөсөн олон ажлуудад ямар нэгэн фокус дутаад байх шиг. Өмнө нь ч олон жил яриад хийж чадаагүй ажлуудыг жагсаасан байна. Үүнээс харахад оролцогч талууд маань нэг зүйлд фокуслах шаардлагатайг харуулж байна гэж бодож байна. Бидэнд тулгамдаад байгаа гол асуудал нь мэдээллийг олон нийтэд хүргэх ажил гэж сая ярьсан. Тайлан гаргадаг томоохон компаниудын сурчилгаагаар мэдээлэл олон нийтэд хүрээд байдаг, харин тайланд хамрагддаггүй, тайлан гаргадаг гаргадаггүйн зааг дээр байдаг ялангуяа тайлан хамрагддаггүй жижиг компаниудын мэдээлэл байхгүйгээс иргэд олон нийтийг бухимдуулдаг. Тэдгээр компаниудын мэдээлэл нь олддоггүй, тэдний эзлэх хувь нь бага учраас хасагдаад явдаг боловч сум, орон нутгийн хэмжээнд маш их нөлөөтэй байдаг. Энэ мэдээлэл нь олддоггүй, үүнээс болоод тайлангийн мэдээлэл олон нийтэд хүрдэггүй, олон нийт сонирхдоггүй, ашигладаггүй гэсэн асуудал гарч ирээд байна. Хэрвээ тусгай зөвшөөрөлтэй бүх компаниудын мэдээллийг ил болгочихвол мэдээллийн дата өгөгдөл нэмэгдэж, түүнийг ашиглах ашиглалт сайжирна гэж бодож байна. Хэрвээ мэдээлэл ил болж чадвал түүнийг хүргэх гээд заавал их ажил болоод байх шаардлагагүй, өнөөдрийн Эрдэнэчимэгийн танилцуулсан хакатон гэж мэдээллийг дунд нь боловсруулаад олон нийтэд хүргэх ажлыг хийж байгаа төрийн бус байгууллага, залуучууд байна. Бүх компанийн мэдээллийг ил болгоно гэдэг нь хэцүү ч гэсэн хамруулж чадвал сайн. Жижиг компаниудын мэдээлэл бага, том компаниудтай адил мэдээлэл байхгүй ч байж болно. Мэдээллээ өгөхгүй, лицензээ зараад, зугтаагаад яваад байна гэдэг нь хүртэл өөрөө мэдээлэл юм. Ийм учраас 2021 ажлын төлөвлөгөө мэдээллийг ил тод болгоход фокуслах саналтай байна.

Одоо хэлэлцэж байгаа ажлын төлөвлөгөөний хүрээнд юмуу, харилцаа холбооны стратегийн асуудлыг ярихдаа эсвэл тусгай цаг гаргаад стандарт маань яагаад хэрэгжихгүй, жил ирэх тусам мэдээлэл ил болгох нь ухраад байгаа талаар ярилцмаар санагдаж байна. Ажлын төлөвлөгөө ерөнхийдөө болж байна гэхдээ жаахан фокуслаад, дэс дараатай болгоод зөв юмаа фокуслаад явбал дараачийн асуудал араас нь залагдаад шийдэгдэнэ гэж харагдаад байна. Тийм учраас цаашдаа тайлагналын механизм ямар байх талаар тусдаа уулзаж ярилцах саналыг дахин хэлье. За баярлалаа.

Ш.Цолмон: Өөр санал байхгүй бол шийдвэрийн төслийн батлаад дараагийн асуудлаа сонсоё. Дорждарийн гаргасан саналын дагуу ач холбогдоор нь бодоод тусад нь 19 дүгээр зорилт болгон оруулах нь зөв байх гэж бодож байна.

Гарсан шийдвэр:

1. ОҮИТБС-ын 2020 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2021 оны ажлын төлөвлөгөөний төсөлд хурлаас гарсан санал, зөвлөмжийг тусган Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах;

Танилцуулга нэг: Монголын ОҮИТБС-ын 2019 оны нэгтгэл тайлангийн төсөл.

Н.Эрдэнэцог: Грант Торnton аудит 2020 оны 10 сард гэрээ байгуулаад 11 сарын 2-ны өдрөөс ажлаа эхэлсэн. Үндсэндээ 5 хоногийн дотор эхлэлийн тайлангаа танилцуулаад, ажлын хэсгээр батлуулсан байгаа. Ажил эхэлснээс хойш хөл хорионы үе таарсан. Тайлангийн төслөөр танилцуулга, цар хүрээ, нэгтгэлийн тохируулгын үр дүн, суурь мэдээлэл, нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийн талаар товч танилцуулна. 2019 оны нэгтгэл тайланг зайнаас ажиллах хэлбэрээр богино хугацаанд хийж гүйцэтгэлээ, бид 12 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан. Ажил эхэлснээс хойш анхны зөрүүгээ гаргаад төрийн байгууллага болон компаниуд руу албан бичиг явуулсан. Тайлангийн хүрээнд нийт 15 төрийн байгууллагад албан бичиг хүргүүлснээс 6 байгууллага хариу ирүүлсэн үлдсэн АМГТГ, БОАЖЯ, УУХҮЯ зэрэг 9 байгууллагаас өчигдрийн байдлаар хариу ирүүлээгүй байсан. Үүнээс хойш 2,3 байгууллагаас хариу ирүүлсэн байсан нь энэ тайланд ороогүй байгаа. Орон нутгийн засаг захиргааны нэгж 20 аймаг, 8 дүүргэгүү бичиг явуулсан үүнээс 2 дүүргэс хариу ирсэн бусад нь хүлээгдэж байна, Нэгтгэлд хамрагдсан 171 компаниас нийт 77,8% буюу 133 компани хариу ирүүлж, Ковид 19-с шалтгаалж 7% буюу 12 компани удахгүй ирүүлнэ, 12.3% буюу 21 компани 12 сарын 14-нд ажил орохоор хариу өгнө гэсэн байна. Огт холбогдох боломжгүй Мэжик Бридж ХХК, Монголчех металл ХХК, Эко хэлхээ ХХК гэсэн 3 компани байна. Энэ 3 компанийт холбогдох мэдээлэл олдоогүй байна. Тайлангийн хамрах хугацаа төлбөр орлогын хувьд 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс 2019 оны 12 дугаар сарын 31 өдөр, суурь мэдээллийн хувьд 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс 2020 оны 6 дугаар сарын 30 байсан. Нэгтгэл тайланд олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй 171 компани, үүнээс 10 нь төрийн өмчийн ААН, Боловсруулах үйлдвэрийн компани 6, газрын тосны ТЗЭ 6, Цацраг идэвхт ашигт малтмалын ТЗЭ 2 байна. Төрийн 14 яам, агентлаг, 1 ТББ, 20 аймаг, 8 дүүргэг хамрагдсан. Тайлангийн цар хүрээний хувьд ОҮ-ийн компаниудаас ЗГ-т төлсөн Материаллаг дүнтэй төлбөрүүдийг нэгтгэхээс гадна • Уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбартай холбоотой олон сэдвийг багтаасан.

Төлбөр, орлогын анхны нэгтгэлээр 122.5 тэрбум төгрөгийн цэвэр зөрүү үүссэн. Энэ зөрүүг задалбал нийт зөрүү 667.4 тэрбум төгрөг байна. ЗГ-ын дунд 295.1 тэрбумын нэмэгдэх тохируулга, компанийн дунд 288.6 тэрбум төгрөгийн нэмэгдэх тохируулгыг тус тус хийсэн. Нэгтгэлийн явцад 37 компани мэдээллээ ирүүлээгүйгээс 42.3 тэрбум төгрөгийн зөрүүг шийдэж чадаагүй. ЗГ-ын зарим байгууллагуудаас мэдээлэл ирээгүйн улмаас нийт 77,667 сая төгрөгийн зөрүү үлдсэн. ЗГ-ын тайлагнасан нийт орлогын 2.17 хувьтай тэнцэх зөрүү тайлбарлагдаагүй үлдэж байна. Нийт ЗГ, компанийн цэвэр зөрүү нь 35.3 тэрбум болж үлдэж байна.

Шинэ маягтаар нийт лиценз эзэмшиж буй 2093 компани тайлангаа илгээх байснаас 633 компани тайлангаа илгээсэн. Мөн Төрийн 2 яам, 4 агентлаг болон орон нутгийн 19 аймаг, 8 дүүргийн засаг захиргаа хүлээн авсан төлбөр, орлогоо цахимаар тайлагнасан байна. Шинэ маягтаар мэдээлэл хангалтгүй байсан тухайлбал, ус ашигласны төлбөрийн мэдээлэл, хог, хаягдлын мэдээлэл, дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба бартерийн солилцоо гэх мэт маятуудын мэдээлэл огт ирээгүй байсан. Мэдээллүүдийг дахин авах цаг хугацаа байгаагүй тул хараат бус нэгтгэгч ирсэн мэдээллүүдийн түвшинд нэгтгэл тайлангаа бэлтгэсэн болно. 2019 оны нэгтгэл тайлангаар дараах зөвлөмжийн хүргүүлж байна. Үүнд боловсруулах салбарын томоохон үйлдвэрлэгч болон туслан гүйцэтгэгч нарыг ОТАХ судалж, улсын төсөвт томоохон хувь нэмэр оруулж буй компаниудыг урьдчилан сонгож, тэдэнд албан ёсоор мэдэгдэж, цахим тайлангийн системд үндсэн мэдээллийг оруулснаар, ил тодын тайланг тушаах нөхцлийг бүрдүүлж, улмаар ОҮИТБС-ын нэгтгэлд хамруулж байх, АМГТГ-ын кадастрын систем, ОҮИТБС-ын цахим систем дэх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгаж, нэг эх үүсвэртэй мэдээлэл дээр цахим тайлангийн системийг ажиллуулах, хөдөө

орон нутагт олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийг кадастрын системд цаг алдалгүй оруулж, олон нийтэд мэдээлэх, Цахимаар авч байгаа мэдээллийг оролцогч талууд баталгаажуулах, бүгдийг олон нийтэд ил тод болгох, эсвэл сонгогдсон компаниудын мэдээллийг хараат бус хянаач нэгтгэгчийн зүгээс үнэлж, сайжруулан олон нийтэд ил тод болгох талаар хэлэлцэх нь зүйтэй, Олборлох салбарын бүх ТӨААНийн аудитлагдсан иж бүрэн санхүүгийн тайланг цахимаар нийтэд мэдээлэх буюу тодруулбал тухайн ТӨААН-ийн өөрийн вэб хуудсанд болон УАГ, ОУИТБС буюу АМГТГЫН вэб хуудсанд тус тус нийтлэх, ТӨААН-үүдийг шилэн дансны хуулийн дагуу мэдээллээ ил тод оруулах, ТӨБЗГ-ын цахим хуудсаар ТӨААН-с хүлээн авсан ногдол ашиг, хамаарах төрийн байгууллагын вебсайтаар дамжуулан ил тод болгон нийтэлж байх тогтолцоог бий болгох, Иймд ОТАХ-ийн зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, цаашид Хараат бус хянаач нэгтгэгчийн оролцоо багасах үед тоо мэдээний чанар, үнэн зөв байдал улам илүү тавигдах болно гэдгийн үйл ажиллагаанд аанхаарч ажиллах, ОТАХ-ийн зүгээс тендер зарлах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа төрийн хууль тогтоомжийг чанд мөрдөж, төлөвлөгөөт цаг хугацаандаа гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байхад хяналт тавьж, дүрэм журмыг чанд мөрдөж ажиллахыг шаардаж ажиллахыг тус тус зөвлөмж болголоо. За баярлалаа. /танилцуулга болон тайлангийн төслийг хавсаргав/

Ш.Цолмон: Грант Торnton аудитад баярлалаа, гишүүдээс асуулт, санал байна уу?

Д.Баттулга: Танилцуулгын файлаар өгч болох уу?

Ш.Цолмон: болно, та бүхэнд тараана. Мөн тайлангийн хавсралт дөнгөж сая файлаар ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа, танилцаарай.

Н.Баярсайхан: Асуулт байхгүй, санал байна. Цаг үеийн нөхцөл байдал, тендерийн будлиан, коронагоос болоод хүнд нөхцөл байдалд чадахаараа ажиллаж байна гэж байна. Чадахаараа биш илүү сайн ажиллахыг хичээмээр байна. Дараа дараагийн жилүүдэд энэ жилийн хийсэн тайлангийн чанар нөлөөлөх учраас хариуцлагатай хийх байх гэж найдаж байна. Одогоор цаг тулсан, сайжруулах боломж байхгүй учраас хүмүүст санал байхгүй байх, надад бас санал алга байна. Шийдвэрийн төслийг дэмжиж байна.

Ш.Цолмон: За баярлалаа. Шийдвэрийн төслийг урьдчилан хүргүүлсэн байгаа, энэ талаар санал байвал хэлнэ үү.

Б.Батболд: Зарим байгууллагаас нэмэлт материалыуд хоцорч ирсэн гэж байна үүнийг хэзээ нэмж оруулж бэлэн болгох вэ?

Н.Эрдэнэцог: Бид Үндэсний зөвлөлд танилцуулахаас өмнө тайланд оруулах мэдээллийг нэмж оруулан, эцсийн байдлаар бэлтгэж танилцуулна.

Б.Батболд: Мэдээллээ өгөхгүй байгаа байгууллагуудад авах арга хэмжээ, зөвлөмжийг сайн тодорхой тусгамаар байна. Өнөөдөр гэхэд цөөн байгууллага харагдаж байна. Хуралдаа суухгүй байгаа юм чинь мэдээлэл хүрэхгүй гэсэн үг. Төрийн аудит, Гааль зэрэг байгууллагууд оролцох ёстой. Эдгээр байгууллагууд мэдээллээ өгөхгүй, хуралдаа суухгүй байгааг зөвлөмжид сайн дурдмаар байна. Одоо УУХҮЯ-нд ирчихэээд зөвлөмж нь үр дүн багатай, хэлж байгаа юм нь цааш хурдэггүй ийм байдалтай байхад энэ үйл ажиллагаа амжилттай явахад учир дутагдалтай байна, иймд нилээн сайн хатуухан хэлмээр байна. Тэгэхгүй бол нэг л аргацаасан байдалтай тайлан болоод байна. Иймээс нилээн хүчтэй, дээш доош нь хурэхээр, анхаарал хандуулахгүй бол болохгүй болчихоод байна.

Ш.Цолмон: Үндэсний зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах боломжгүй иймээс цахимаар гишүүдээс санал авах замаар зохион байгуулахаар өнөөдрийн хурлын шийдвэрт тусгагдсан байгаа үүнийг танилцуулж байна. Энэ талаар саналаа давхар хэлж болно. Ирэх долоо хоногийн нэг дэх өдөр гэхэд Үндэсний зөвлөлд танилцуулах материалыг гишүүдэд хүргүүлэх болно.

Д.Цэрэнжав: Компани, төрийн байгууллагаас цөөн хүн байна уу эсвэл саналаа хэлэхгүй байна уу? Саналыг хураах юм уу тоолж нэгтгэх үү?

Ш.Цолмон: эсрэг саналтай гишүүн байхгүй байна, ингээд нэгдүгээр асуудлаа дуусгая. Баярлалаа.

Гарсан шийдвэр:

1. Монголын ОҮИТБС-ын 2019 оны нэгтгэл тайлангийн төслийг зарчмын хувьд дэмжиж, Ажлын хэсгийн санал, зөвлөмжийг нэмж тусгасны үндсэн дээр Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах;
2. Грант Торnton Аудит ХХК-тай 2020 оны 11-р сарын 11-ний өдөр байгуулсан 79 тоот гэрээний тусгай нөхцлийн 6.4-р заалтын дагуу нийт төлбөрийн 50 хувь буюу 59,977,500.00 төгрөгийг тус компанийн дансанд шилжүүлэхийг ОҮИТБС-ын Ажлын албан (Ш.Цолмон) зөвшөөрөх;

Танилцуулга гурав: ОҮИТБС-ын сургалтын модуль, оролцогч талуудын зураглал, харилцааны стратегийн төслийн танилцуулга

Л.Байгал: ОҮИТБС-ын оролцогч талуудын талаар зураглал хийсэн. Бүх талуудаас судалгаа аваад, ОҮИТБС-ын үр ашиг, сонирхлыг нэгтгэн оруулсан. Энэ судалгааны үр дүнд хэд хэдэн зөвлөмжийг гаргасан. Бид ОҮИТБС-ын нэгтгэл тайлан гаргах, оролцогчид жилээс жилд нэмэгдэж, ахиц дэвшил гарч байгаа боловч, ил тод болсон мэдээллийг олон нийтэд хүргэх ажил дутагдалтай байна. Тухайлбал, орон нутагт байгаа иргэдэд танигдахын тулд нөлөөллийн бүсэд байгаа дэд зөвлөлүүдийг бий болгож, тэдний үйл ажиллагааг тогтмол болгох, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, үүнийг онлайн хэлбэрээр сардаа нэг удаа ч юм уу тогтмол болгох идэвхжүүлэх хэрэгтэй байна. Дэд зөвлөлүүдийг тогтвортой явуулахын тулд санхүүжилтийн асуудлыг шийдэх хэрэгтэй. Энэ талаар Засгийн газрын 2017 оны 263 дугаар тогтоол байдаг боловч одоог хүртэл хэрэгжихгүй байна. Тэгэхээр энэ тогтоолын хэрэгжилтийг хангах талаар орон нутагтай хамтарч ажиллах хэрэгтэй байна. Мен тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, компаниудтай санамж бичиг байгуулан санхүүжилтийн тодорхой хэсгийг шийдэх боломжтой гэж үзэж байна. Үүний үндсэн дээр харилцааны стратегийг боловсруулсан байгаа энэ талаар танилцуулъя.

Ил тод болгосон мэдээллийг хэрхэн олон нийтэд хүргэх талаар мэдээллийн шинэ сувгуудыг санал болгосон байна. Бид хэдийгээр орон нутгийн сургалт, уулзалт хийж байгаа ч мэдээллийн хүртээмж сайжрахгүй, ОҮИТБС-ын талаарх мэдлэг мэдээлэл муу байна. Иймд олон нийтэд хүргэхэд анхаарах хэрэгтэй байна. Энэ стратеги нь өмнө боловсруулсан стратегийг сайжруулах замаар хийгдсэн байгаа. Уг стратегид нэгдмэл байх, Мэдээллийн хөрөнгө оруулалт, хамтарч ажиллах, холбоо сүлжээ бий болгох гэсэн зорилтын хүрээнд бэлтгэсэн байна. ОҮИТБСМ-ын профайлын өсгөхийн тулд Харилцааны төрөл бүрийн сувгуудыг ашиглах, Олборлох үйлдвэрлэлийн салбараас МУ-д үзүүлэх нөлөөлөл болон хувь нэмрийн талаарх олон нийтийн мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх, Мэдээллийг үр ашигтай хэлбэрээр түгээх, мэтгэлцээнийг дэмжих болон хариуцлагыг нэмэгдүүлэхэд одоогийн байгаа data мэдээллүүдээ ашиглах, ОҮИТБСМ-ыг сурталчлахаар Олон талт бүлэг (ОТБ)-ийн гишүүдийг хуваарилан авсан нөлөөллийн тойротоо ажиллахад зохион байгуулах, баримтжуулах, Олон талт бүлгийн оролцогч талууд болон олон нийтийн төлөөлөлтэй хэрхэн Харилцах талаарх Харилцааны төлөвлөгөө гаргаж ОТБ-тэй зөвшилцэх, Олборлох үйлдвэр, иргэний нийгэм, засгийн газар болон бусад оролцогчдын дундах мэдээллийг дээшшуулэх болон тухайн үйл явцад тэд хэрхэн оролцох талаар нэмж боловсруулсан. Стратегийн хүрээнд гол дөрвөн зорилtot бүлгүүдэд тулгуурлаж ажиллах зорилт тавьсан. Үүнд: УИХ-ын гишүүд, нутгийн иргэд, сэтгүүлчид, эрдэмтэн судлаачид байна. Мэдээллийг хэрхэн түгээх тал дээр судалгаа хийсэн. Оролцогч талууд болон төрийн албан хаагчид ямар мэдээллийн сувгаар мэдээлэл авч байгааг судалсан. Уг

судалгаанд үндэслэн бид ОҮИТБС-ын мэдээллийг ямар байдлаар түгээж болохыг гаргасан. Үүний дараа харилцаа холбооны механизмыг боловсруулах ажлыг хийж байгаа үнд цахимаар яаж ажиллах вэ, вэбсайтад ямар платформыг ашиглаж мэдээллийг түгээх, хэрхэн тогтмолжуулах вэ зэрэг асуудлыг боловсруулж байна. Үүнээс гадна санхүүжилтийг хэрхэн шийдэж болох талаар тодорхой жишээнүүдийг дурдсан байгаа. Мэдээллийг тогтмол түгээх, ажиллагааг тогтворжуулахын тулд мэргэшсэн харилцааны мэргэжилтнийг ажлын албандаа ажиллуулах шаардлагатай байна. Үүнийг хангалтгүй гэвэл PR чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зөвлөх байгууллагыг ажиллуулвал илүү хүртээмжтэй болж өгнө. Та бүхэнд урьчилан танилцуулсан тул товч танилцууллаа, санал асуулт байвал хариульяа. (материалыг хавсаргав)

Б.Батболд: Оролцогч талуудаас Иргэний нийгмийн байгууллагаас ямар байгууллагаас судалгаа мэдээлэл авсан бэ? Үүнээс МБОИЗ-ын байгууллагаас санал асуулга авсан уу?

Л.Байгал: Танилцуулгад ямар ямар байгууллагаас хэрхэн санал, асуумж авсан талаар дурдсан байгаа. МБОИЗ-ын ажлын албанаас асуулга утсаар авсан яг хэнээс авсныг хэлэх боломжгүй. Асуулгад хамтран ажилладаг гишүүдээс илүүтэйгээр бусад байгууллага, хүмүүсээс авахыг зорьсон.

Н.Баярсайхан: Байгальг стратегийн баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлж байна гэж ойлгож байна. Иймээс бид сайн чанартай баримт бичиг авах ёстой. Үүний өмнө стратегийн баримт бичиг боловсруулсан байсан үүнийг дүгнэсэн үү. Бид хуучнаа дүгнэж байж, нөхцөл байдлаа ямар байгааг харна. Хуучин стратегийн хувьд болж байсан сайн талууд юу байна, сүл тал юу байна вэ? Энэ хэзээнээс эхэлсэн ажил вэ? Бусад улс орнуудын харилцааны стратегиудаас авсан сургамж юу байна, үүнийг үнэлж үзсэн үү, тантай хамтарч байгаа баг байгаа юу? Баримт бичиг агуулгын хувьд ч, бичвэрийн хувьд ч маш дутуу, хангалтгүй, ноорог шахуу байсан одоо ч хэвээрээ байна. Иймд өнөөдрийн хуралдаанаар батлах боломжгүй байна. Энэ бичиг баримт маань маш сайн боловсруулагдаж байж бид цаашид үүнийг ашиглах ёстой. Зөвлөхөөс бид сайн материал хүлээж авах ёстой, төлбөр төлөгдөөд гэрээ дуусаад явахад бид түүхий баримт бичигтэй үлдэнэ, үүнээс болгоомжилж байна. Ийм саналтай байна.

Л.Байгал: Би энэ оны 4 сараас ажилдаа орсон. Үүнээс хойш сургалтын модуль, стратеги гээд хоорондоо харилцан уялдаатай бичиг баримтууд боловсруулах ажлыг хийж байна. Үүний дараагийн ажил бол харилцааны платформ буюу харилцааны механизм гэсэн дараагийн бичиг баримт байгаа. Өмнө нь 2014 онд боловсруулсан Харилцааны стратеги байгаа энэ стратеги маань түүний нэгээхэн хэсэг болж байгаа, өөрөөр хэлбэл шинэчлэлтүүдийг хийж өгсөн. Үүнийг нөхцөл байдлын товчоо гэдэг хэсэгт тодорхой оруулсан байгаа. Энд өмнөх стратегиа дүгнээд юу нь болж байна, юун дээр алдсан гэдгийг дүгнэж оруулсан. Үүний үндсэн дээр энэ стратегийн зорилтуудыг оруулж, зорилтод бүлгүүдээр харуулсан. Баримт бичгийг боловсруулахдаа санаачилгад нэгдсэн улс орнуудын бичиг баримт, судалгаануудыг судалж, танилцаж хийсэн. Шаардлагатай бол дараа нь тэдгээр байгууллага улс орнуудын жагсаалтыг хүргүүлье. Ажлын албаныханаас санал аваад тусгаж оруулсан байгаа. Одоогоор ажлын хэсгийн гишүүдээс санал ирээгүй, Баярхүү зохицуулагчаас ирсэн саналыг тусгасан.

Н.Баярсайхан: Оролцооны талаар хангалтгүй байгаа юм байна, ганц хоёр хүнээс санал авсан юм байна, өөрөө л хийж байна уу?

Л.Байгал: Би ганцаараа ажиллаж байгаа баг гэж байхгүй гэрээний дагуу Ажлын албатай хамтраад хийж байгаа.

3.Баярхүү: Ажлын хэсгийн гишүүдээс өгч байгаа саналыг дэлгэрэнгүй тусгаж, хүснэгтлээд хариуг өгөх ёстой. Хэнээс ямар санал гарсан түүнийг ямар хэлбэрээр хаана тусгасан гэдгийг тодорхой байдлаар харуулах. Жишээлбэл, харилцааны мэргэжилтэн

ажиллуулах санал дэвшиүүлж байгаа бусад улс оронд санхүүжилтийг хэрхэн шийддэг, ямар байгаа талаар тусгах хэрэгтэй. Мөн судалгаанд бусад улс орнуудыг туршлагааг судалсан гэж дурдаад байна. Үүнийг яг ямар улс орны ямар туршлага байсан зэргийг судалгаандаа тусгайлан оруулах хэрэгтэй байна. Энэ саналыг би 2,3 удаа хүргүүлсэн ч тусгагдахгүй байна. Норвеги гэхэд ямар туршлага байсан, санхүүжилт нь ямар хэлбэрээр байв гэдгийг орон орноор нь хүснэгтлэж оруулаад уг мэдээллийг ямар эх үүсвэрээс авсан гэдгээ тусгамаар байна. Ерөнхийд нь судалсан гэж хариулаад байдаг яг үзэхээр тодорхой юм харагдахгүй байна. Мөн ямар ямар төрийн бус байгууллагуудаас асуумж авсан талаар асуусан түүнийг бас дэлгэрэнгүй оруулах хэрэгтэй. Судалгааг яг хэдэн хүнээс аваад хэдэн хувь нь угүй гэж хариулсан гэдэг нь тодорхойгүй байна. Хэрвээ 20-хон хүнээс авсан бол наад судалгаа чинь чанаргүй худлаа болно. Хичнээн ИНБ-ын хэдээс нь судалгаа авсан зэргийг тусгаж өгмөөр байна. Эдгээр саналуудыг давтан өгч байгаа ч одоог хүртэл хийгдэхгүй байна. Юуны тулд санал аваад байгаа билээ, саналуудыг тусгах хэрвээ тусгахгүй бол яагаад тусгахгүй байгаа талаар тайлбар өгөх хэрэгтэй.

Д.Цэрэнжав: Би Баярсайхан, Баярхүү нарын саналтай санал нэг байна. Бид ажлын даалгаврыг нь үзэх хэрэгтэй. Нилээдгүй шүүмжлэл өрнөж байна гэхдээ нэгэнт ийм ажлын даалгавартай байсан бол ажлыг нь хүлээж аваад дуусгах нь зүйтэй байх. Гэрээний хугацаа нь 12 дугаар сард дуусаж байгаа юм байна. Энэ баримт бичгийг янз бүрийн деталь оруулаад өөрчилж болно гэхдээ мөн чанар нь өөрчлөгдхөгүй. Ер нь стратеги гэдэг нь загвар л байгаа өмнө нь боловсруулсан стратеги нь бидэнд тус болоогүй, саад ч болоогүй. Тэр үед харилцааны мэргэжилтэн Дэлгэрмаа байсан учраас амьдроулаад яваад байсан байна. Тэгэхээр манай ОУИТБС-ын ажиллагаанд харилцааны стратегийн баримт бичиг байгаа байхгүй дээ биш олон нийттэй харилцах асуудлыг шийдэх стратеги боловсруулах ажлын даалгавар өгөөд боловсруулсан бол болох байж гэж бодогдож байна. Шийдэл нь юу вэ гэхээр санаачилга маань өөрөө өөрсдөө мөн чанараа таньж мэдээд, зорилгоо тодорхойлоод, фокуслаад ажиллах нь зөв байх. Нэгэнт ач холбогдол багатай юмыг томруулаад баахан эх сурвалж нэхээд цаг алдаад байхаар боломж байдаг бол хугацааг нь нэг хоёр сараар сунгаад, 2021 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх стратеги боловсруулах боломж байна уу гэсэн саналтай байна. Хүмүүсийн гаргасан саналыг дэмжиж байна гэхдээ цаашид улам томруулаад л байвал сайжрах байх гэвч бидэнд хэрэгтэй зүйл гарахгүй байх гэж бодож байна.

3.Баярхүү: Цэрэнжав гуайн саналтай санал нэгтэй байна гэхдээ томруулахдаа биш шүү, зөвөөр ойлгоорой. Аливаа судалгаанд дурдаж байгаа юмнууд нь заавал үндэслэлтэй, тооцоололтой байх ёстой, ерөнхий юм бичихээд санал хэлэнгүүт ерөнхий байдлаар тайлбарлаад байгаа. Өөрөөр хэлбэл үүнийгээ сайн батлах хэрэгтэй байна.

Л.Байгал: Миний ажлын даалгавраар харилцааны стратегийг шинэчлэх гэсэн байсан. Өмнө 2014 онд боловсруулсан бичиг баримт нь сайн бичиг баримт цаашид үргэлжлээд явах юм. Би энэ бичиг баримт дээр сайжруулалт, нэмэлт хийсэн байгаа. Ашигласан материалын түүврүүдийг нэмээд оруулчихъя, би бичиг баримтаа боловсруулахад тэдгээр улсуудын материалыг харж байгаад энэ нь манайд хэрэгтэй юм байна, сүүлийн үед тулхүү хэрэглэгдэж байгаа арга барил байна гэдгийг уншиж боловсруулаад, цаасан дээр буулгаад оруулсан. Одоо саналуудыг сонсоод эргээд бичгээр хариу өгье.

Т.Мөнхбат: Цэрэнжав гуайн саналтай нийлж байна. Ерөнхийдөө бусад хүмүүсийн хэлсэн гол ғол саналуудыг тусгаад цаг авахгүй энэ бичиг баримтаа ойрын үед дуусгачихвал зүгээр байна. Мөн сүүлийн үед лайв хэлбэрээр мэдээллийг түгээх, нэвтрүүлэг явуулахад анхаарах хэрэгтэй байх, зардал багатай олон хүнд хүрч байгаа. Санчаачилгын цахим хуудсаа сайн идэвхжүүлэх хэрэгтэй байна, энэ бичиг баримтаа жаахан сайжруулах саналтай байна.

Н.Баярсайхан: Ажлын даалгавар ямар байгааг бид мэдэхгүй ч улам сайжруулах, турван талын уулзалт хийж саналыг тусгах хэрэгтэй байна. Зөвлөхийн хувьд ганцаараа

хийж байгаа боловч ажиллах арга барилдаа олон нийтийг оролцуулах юм. Өнөөдөр ярьж байгаагаа цаасан дээрээ буулгах хэрэгтэй байна, засаж сайжруулаад дахин хурлаар оруулах саналтай байна. Төр-Одын мэдээлснээр Евро Азийн бүсэд харилцааны стратеги боловсруулж байгаа юм байна, үүний дагуу асуултууд ирсэн байна, үүнтэй бас уялдуулах хэрэгтэй байх. Ингээд өнөөдөр батлахгүй үлдээе, болж өгвөл ТАН, МБОИЗ болон УҮАСсоциацийн саналыг авч, оролцуулах саналыг хэлье. Бичиг баримт үнэхээр түүхий байна.

Л.Байгал: Өнөөдрийн танилцуулж байгаа бичиг баримт нь өмнөх стратегийг шинэчлэх ажил юм. Одоо хийж байгаа дараагийн бичиг баримт нь харилцааны платформ байгаа, нэг юм боловч тусдаа бичиг баримт байгаа. Баярсайхан гуайн гаргасан санаа нь дараагийн бичиг баримтад хэлж байгаа санаа юм болов уу гэж ойлголоо.

Ш.Цолмон: Гишүүдээс гаргасан саналын дагуу харилцааны баримт бичгийг үлдсэн хугацаанд засаж сайжруулаад дахин Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулах гэсэн байдлаар хуралдааны шийдвэрт тусгах саналтай байна. Харин хэзээ зохион байгуулах боломжтой байна? 7 хоногийн дараа боломжтой юу?

Л.Байгал: Боломжтой

Б.Батболд: Бас нэг бичиг баримт хийж байгаа гэсэн түүнтэйгээ нэгтгээд танилцуувал хоорондоо уялдаад зүгээр болох бишүү. Тэгэхгүй бол дараагийн ярих юм дээр бидний санал гарч ирээд байгаа болохоор нэг мөсөн танилцуулсан нь зөв байх. Цэрэнжав гуайн гаргасан тойроод ярилцах хэрэгтэй байна гэсэн шиг энэ асуудлаараа ярилцах саналтай байна.

Ш.Цолмон: Ерөнхийдөө ямар санал, сайжруулах зүйл байгаа нь ойлгомжтой боллоо үүний дагуу засаж сайжруулаад 7 хоногийн дараа дахин хэлэлцэхээр болж байна. Шийдвэрийн төсөлд ингэж тусгая. Энэ үед дараагийн бичиг баримт чинь бэлэн болж амжих уу?

Л.Байгал: Арай амжихгүй байх

Н.Баярсайхан: Аль 4 сард эхэлсэн юм бол ажил нь яаж яваад байгааг ойлгохгүй байна, одоо 10 гаруйхан хоногт амжих юм уу? Цаг хугацаанд шахагдаад дутуу юм авч болохгүй, төлбөрөө өгөхгүй байж, хугацааг сунгах хэрэгтэй байна.

Л.Байгал: 28 нд болж байна.

Д.Цэрэнжав: Тэгвэл 28-нд харилцааны стратегийн баримт бичгийг багцаар нь хэлэлцэнэ гэж ойлголоо. Бид санал хэлж байна гэдэг нь чамд туслах гээд байна. Иймээс үүнээс өмнө Баярсайхан, Батболд нарын хэлснээр бидэнтэй холбогдоод ярилцлага, санал авч болох юм.

Ш.Цолмон: тийм, цагийг нь жич зарлай. Хурлын шийдвэртээ дахин уулзахаар боллоо гэдгээр оруулья.

Л.Төр-Од: Манай ТАН эвслийн Евро Азийн бүс нутгийн салбараас харилцааны стратеги боловсруулж байгаа юм байна. Үүнтэй холбоотой асуумжийг өчигдөр орой ирүүлсэн байна, бид ТАН эвслийн гишүүдээс авах юм. Үүнийг танилцуулсан нь харилцааны стратеги боловсруулахдаа агуулга талаас нь харгалзаж үзээч, өөрөөр хэлбэл анхааралдаа аваач гэдэг санаагаар хүргүүлж байна.

Л.Байгал: Ажлын хэсгийн гишүүдээс өөр санал байвал имэйлээр ирүүлэхийг хүсэж байна, би саналыг тусгаад хариу өгөх болно.

Ш.Цолмон: Үндэсний зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах боломжгүй учраас цахимаар саналыг авах гэсэн шийдвэрийг дэмжиж байна уу, саналаа өгнө үү. Үүнээс өмнө хуралдаанаас хэлэлцэх материалыг имэйлээр хүргүүлэх болно. Өнөөдрийн хуралдааны материалыудыг явуулсан байгаа. Хурлын тэмдэглэл гарна, түүнд саналаа өгөөрэй. Хуралдаандаа идэвхтэй оролцсон та бүхэндээ баярлалаа.

Гарсан шийдвэр:

1. ОУИТБС-ын сургалтын модуль, оролцогч талуудын зураглал, харилцааны стратегийн баримт бичгийн төсөлд Ажлын хэсгийн санал, зөвлөмжийг тусган шинэчлэн боловсруулж, дахин 12 дугаар сарын 28-ны дотор танилцуулах;
2. COVID-19 цар тахлын улмаас үүсээд буй нөхцөл, байдалтай холбогдуулан Үндэсний зөвлөлийн гишүүдийн саналыг цахим хэлбэрээр авч, холбогдох шийдвэрүүдийг гаргуулах ажлыг зохион байгуулахыг Ажлын албан (Ш.Цолмон) даалгав.

Хуралдаан 13.40 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга,
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн
бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч

Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалсан, тэмдэглэлийг хянасан:

УУХҮЯ-ны Судалгаа хөрөнгө оруулалтын газрын
дарга:

Э.Батболд
Ш.Цолмон

ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОУИТБС-ын Ажлын албаны
Санхүүгийн ажилтан

А.Отгонзунгалаг